

ОРОС ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВҮҮД

Б.Даваасүрэн

Нэг. Казанийн монгол судлал

1804 онд нэгдүгээр Александр хааны зарлигаар Казанийн их сургууль анх байгуулагдахад түүний бүрэлдэхүүнд дорно дахины хэлний тэнхим гэсэн ерөнхий нэртэй нэгэн тэнхим байсан бөгөөд хамгийн анх И.И.Хальфин татар хэл, Х.Д.Френ араб, перс хэл зааж эхэлсэн ажээ.

Хожим 1828 онд тус тэнхимийн бүтцийг задалж, араб-перс, түрэг-татар хэлний тэнхим байгуулж, улмаар 1833 онд монгол хэлний тэнхим, 1837 онд хятад хэлний тэнхимийг шинээр нээжээ. Тэнд А.К.Казем-Бек, И.Н.Березин, Ф.И.Эрдман, И.Ф.Готвальд зэрэг дорно дахины судлалын нэртэй эрдэмтэд ажиллаж байсан байна.

Монгол хэлний тэнхим нээсэн үйл явдал нь тус сургуулийн захирал, математикийн ухааны алдарт эрдэмтэн Н.И.Лобачевский (1792-1856), залуу эрдэмтэн О.М.Ковалевский (1801-1878) нарын идэвх санаачилгатай шууд холбоотой. О.М.Ковалевский Вильнюсийн Их Сургуулийг төгссөний сүүлээр филоматуудын нууц бүлгэмд элссэн хэмээн буруутгагдаж, 1824 онд Казань руу цөлөгдсөн байна. Казанид очсоны сүүлээр судалгааныхаа чиглэлийг өөрчилж дорно дахины судлаач болсон ажээ. Тус сургуулийн араб-перс хэлний ангид суралцаж төгссөн польш гаралтай О.М.Ковалевский эртний түүхтэй монголчуудын хэл соёлыг үргэлжлүүлэн сурах хүсэлтээ их сургуулийн захирлын нэр дээр гаргажээ. Профессор Н.И.Лобачевский түүний хүсэлтийг хүлээж аваад Хаант Оросын Гэгээрлийн яаманд уламжилсан нь төдөлгүй зөвшөөрөгдсөн учир 1828 оны хавар араб-перс хэлний ангид хамт суралцан төгссөн О.М.Ковалевский, А.В.Попов (1808-1865) хоёрыг монгол хэл сургахаар Эрхүү хот руу илгээжээ. Тэднийг тэр үеийн буриадын томоохон сэхээтэн Александр Васильевич Игумнов (1761-1834) хүлээн авч, монгол хэлийг тусгай хөтөлбөрөөр заажээ. Тэд Эрхүүд 5 жил суралцахдаа зөвхөн монгол хэл сураад зогссонгүй, О.Ковалевский манж, хятад, төвөд, санскрит зэрэг дорно дахины дөрвөн хэлийг нэмж сураад, монголчуудын зан заншил, соёл шашны холбогдолтой 1500 шахам боть ном цуглуулсан бол А.В.Попов монгол аман зохиол, угсаатан судлалын баялаг материал цуглуулжээ.

О.Ковалевский, А.В.Попов хоёр 1833 оны хавар Эрхүүгээс эргэж ирээд, монгол хэлний мэдлэг чадвараа үнэлүүлэхээр Санкт Петербург хотод очиж, Оросын ШУА-ийн монголч эрдэмтэн И.Я.Шмидт (1779-1847)-д шалгуулж, өндөр үнэлгээ авч, их сургуульд багшлах эрх авчээ. Академич Я.Шмидтийн үнэлгээг үндэслэн Казанийн их сургуульд монгол хэлний тэнхим нээж, О.Ковалевский, А.В.Попов нарыг багшлуулах тухай Хаант Оросын Гэгээрлийн яамны шийдвэр 1833 оны 7-р сарын 25-нд гарсан байна. Ингээд 1833 оны 9-р сарын 11-ны өдөр Казанийн их сургуульд монгол хэлний анги нээж, монгол хэлийг сургаж эхэлсэн нь зөвхөн Казань их сургууль төдийгүй, Орос орон, тэр ч байтугай нийт өрнө дахинд монгол хэлийг их сургуулийн төвшинд заах, улмаар монголчуудын түүх, соёлыг тогтолцоотой арга зүйгээр судлахын эхлэл нь болсон байна. Шинэ тутам нээгдсэн монгол хэлний ангид О.Ковалевский “Монгол ярианы хэл”, “Монгол бичгийн хэл”, “Монголын түүх”, “Монголын утга зохиолын түүх”, “Бурханы шашин” зэрэг хичээл зааж байсан бол А.Попов “Монгол хэлний өгүүлбэр зүй”, “Монгол хэлний үгийн гарал зүй”, “Монгол бичиг үсгийн түүх”, “Монголын түүх” зэрэг хичээл зааж байжээ. Тэд зааж байгаа хичээлийнхээ гарын авлага болгож өөрсдийнхөө бэлтгэсэн

“Монгол хэлний хураангуй хэлзүй”, “Монгол-орос толь”, “Монгол-буриад хэлний ярианы дэвтэр”, “Монгол-орос хураангуй толь” (5000 үгтэй), “Монгол-орос дэлгэрэнгүй толь бичиг” (40 000 үгтэй) болон халимаг аялгуу, аман зохиолын баялаг материалыг ашиглаж байжээ. Багш, оюутнууд чөлөөт цагаараа монголчуудын дунд хэл аялгуу, аман зохиол, зан үйлийн материал цуглуулах ажлаар явж, монголын түүх соёлын холбогдолтой эртний ном судар болон амьд хэл аялгууны материал цуглуулснаа сургалт, судалгаандаа өргөн хэрэглэж байжээ. Монгол хэлний анги нээгдээд төдий л удаагүй байхад О.Ковалевскийн “Монгол ном бичгийн хэлний хураангуй хэлзүй” (1835), “Монгол утга зохиолын унших бичиг” (1836, 1837), “Монгол-орос-франц толь бичиг” (1844-1849), А.Поповын “Халимаг хэлний зүй” (1847), А.Бобровниковын “Монгол халимаг хэлний зүй” (1849) зэрэг номууд хэвлэгдэн гарсан нь зөвхөн сургалтын гарын авлага болсон төдийгүй, монгол хэлний судлалыг үлэмжхэн ахиулсан чухал үнэтэй бүтээл болжээ. О.М.Ковалевский 1862 онд Варшавын Их Сургуулийн түүх-хэл бичгийн ухааны салбарын захирлаар томилогдон Польшид очсоноос хойш дорно дахины судлалын ажлаа зогсоосон аж.

Казанийн их сургуулийг монгол судлалын чиглэлээр төгсөгчдийн дотроос Доржи Банзаров (1822-1855), К.Ф.Голстунский, А.А.Бобровников (1821-1865) нарын зэрэг нэрт монголч эрдэмтэд төрөн гарчээ.

Н.И.Лобачевскийн санаачилгаар 1834 онд “Казанийн их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг”-ийг хэвлэх болсон хийгээд эдүгээ тус эрдэм шинжилгээний бичиг Хүмүүнлэгийн ухаан, Байгалийн шинжлэх ухаан, Физик-математик гэсэн гурван төрлийн цувралаар хэвлэгддэг.

Профессор О.М.Ковалевский, А.Попов нар эхлэлийг нь тавьж хөгжүүлсэн Казанийн монгол судлалын тэнхим нь гуч гаруйхан жилийн хугацаанд монгол судлалын цогц үйл ажиллагаагаараа Орос орон төдийгүй, өрнө дахинд хүлээн зөвшөөрөгдөж, зохиол бүтээлүүд нь олон газар түгэн дэлгэрч, дорно дахины судлалын түүхэнд “Казанийн дэг сургууль” хэмээн алдаршсан билээ. 1855 оны намар Казанийн их сургуулийн дорно дахин судлалын салбарыг бүхлээр нь Санкт Петербургийн их сургуульд шилжүүлэх болсон тул үүсэн байгуулагдсанаасаа хойш 22 жилийн турш сургалт, судалгааны идэвхтэй үйл ажиллагаа явуулсан тус тэнхим ч бас шилжсэн байна. Хэдий тийм боловч Казанийн их сургууль нь Орос орон дахь монгол судлалын ууган өлгий гэдэг хүндтэй байр суурь нь түүхэнд мөнхрөн үлдсэн юм.

Хоёр. Санкт-Петербургийн Монгол судлал

Орос орон дахь Монгол судлалын эхлэл нь Петербург дэх Эзэн хааны ШУА-д анх тавигджээ. XIX зууны эхээр Голланд гаралтай И.Я.Шмидт (1779-1847) Сагансэцэний “Эрдэнийн товч”-ийг герман хэлээр орчуулж, улмаар “Монгол хэлний хэлзүй” хэмээх бүтээлийг 1831 онд нийтлүүлсэн нь Оросын монгол судлалын эхлэл болсон байна. Мөн Петербург хотноо Оросын Газарзүйн нийгэмлэг (1845), Оросын Археологийн нийгэмлэг (1846)-ийг тус тус байгуулж, Н.М.Пржевальский (1839-1888), Г.Н.Потанин (1835-1920), М.В.Певцов (1843-1902), П.К.Козлов (1863-1935), В.А.Обручев (1863-1956) зэрэг нэрт эрдэмтэд Сибирь болон Төв Ази, түүний дотор Монголын түүх, газарзүйн тухай баялаг материал цуглуулж, Азийн музейн сан хөмрөгт нийлүүлж байжээ. Түүнчлэн дээрх эрдэмтдийн бичсэн олон сонирхолтой ном бүтээл нийтлэгдсэн нь Монгол судлалыг үлэмжхэн баяжуулжээ.

Түүний дараахан 1854 онд Казанийн их сургуулийн дорно дахин судлалын салбарыг Санкт-Петербургийн их Сургуульд шилжүүлэх тухай Эзэн хааны зарлиг гарсны дагуу 1855 оны намар тус салбар бүрмөсөн шилжсэнээр Орос орон дахь монгол судлалын сургалт-судалгааны гол төв нь Санкт-Петербург болсон түүхтэй. Петербургийн их сургуульд шинэ тутам байгуулсан монгол-халимаг хэлний тэнхимд монгол хэлний хичээл заах өндөр мэргэжлийн багш нэгэнт байхгүй байсан тул А.В.Попов, К.Ф.Голстунский нарыг Казаниас урьжээ. Профессор А.Попов тус тэнхимийг 15 жил толгойлсны зэрэгцээ “Монгол хэл”, “Халимаг хэл”, “Монгол бичгийн хэл”, “Монгол угсаатны зүй” зэрэг хичээл зааж байв.

1860 онд профессор А.В.Попов өөр ажилд шилжсэн учир түүний шавь, хамтран зүдгэгч К.Ф.Голстунский тус тэнхимийг дөч гаруй жил толгойлж, “Монгол хэл”, “Халимаг хэл”, “Буриад хэл”, “Монгол утга зохиолын түүх”, “Монгол бичиг” зэрэг хичээл зааж байжээ. Тэрбээр олон жил цуглуулсан баялаг материал дээрээ тулгуурлан гурван боть “Монгол-орос толь” зохиосон нь Ковалевскийн толийн дараа орох томоохон бүтээл болж, сургалт, судалгааны ажилд өргөн хэрэглэгдэх болжээ.

Петербургийн их сургуулиас төрж гарсан анхны том эрдэмтэн бол А.М.Позднеев юм. Тэрбээр 1876 онд Петербургийн их сургуулийг монгол, манж, хятад судлалын чиглэлээр төгсөөд монгол орноор хэд хэдэн удаа аялж, ардын аман зохиол, зан заншил, шашин суртахууны холбогдолтой баялаг материал, мянга орчим ховор нандин ном судар цуглуулж, Петербургийн их сургуулийн номын санд өгсөн нь сургалт-судалгааны үнэлж баршгүй өв сан болжээ. Мөн түүний бичиж нийтлүүлсэн “Монгол орон ба Монголчууд”, “Монгол туургатны ардын билиг зүйн дээж”, “Монгол дахь бурхны шашны сүм хийд ба бурхны шашны лам хуврагуудын ахуй амьдралын тухай найруулал” зэрэг бүтээлүүд нь оюутан залуус, дорно дахины судлаачдын анхаарлыг татсан чухал бүтээлүүд болсон байна.

А.М.Позднеев (1851-1920) 1881 оноос Петербургийн их сургуульд “Монголчуудын үсэг бичгийн түүх”, “Монгол хэл аялгуунууд”, “Монгол хэлтний утга зохиолын түүх”, “Манж хэл” зэрэг хичээл зааж эхэлсэн бөгөөд хожим монгол бичиг, дөрвөлжин үсгийн монгол дурсгалуудын талаар түүний заасан хичээл нь “Монголын утга зохиолын лекцүүд” гэсэн нэртэй гурван дэвтрээр хэвлэгдсэн нь монгол судлалын түүхэнд мөнхрөн үлджээ.

XX зуун гарсаар Петербургийн их сургуулиас В.Л.Котвич (1872-1944), А.Д.Руднев (1878-1958), В.В.Бартольд (1869-1930), С.А.Козин (1879-1956), Г.Ц.Цыбиков (1873-1930), Б.Б.Барадин (1879-1937), Ц.Ж.Жамцарано (1880-1940), Б.Я.Владимирцов (1884-1931) нарын зэрэг нэрт эрдэмтэд залгамжлан гарч, монголын судлалд үлэмж их хувь нэмэр оруулсан байна.

1899 онд профессор К.Ф.Голстунский таалал төгсөж, А.М.Позднеев алс дорнодод шилжсэний дараа тэдний шавь, манж, монгол, хятад судлалын чиглэлээр мэргэжсэн польш эрдэмтэн В.Л.Котвич (1872-1944) монгол-манж хэлний тэнхим шинээр байгуулан, түүнийг толгойлох болжээ. Тэрбээр тус тэнхимийг бараг хорин жил удирдахдаа “Монгол хэлнүүдийн харьцуулсан хэлзүй”, “Халимаг хэл”, “Халимаг бичиг үсгийн түүх”, “Манж хэл”, “Монгол бичгийн хэл”, “Дундад Азийн нүүдэлчин аймгуудын түүх” зэрэг хичээл зааж байснаас гадна монгол хэл аялгууны судлал, бичгийн дурсгалын судлалыг голлон анхаарч, монгол, халимаг хэл аялгууг судалж, “Монгол хэлзүйн лекцүүд”, “Халимаг аман ярианы хэлзүй” гэх зэрэг томоохон бүтээлүүд туурвисны дээр монгол бичгийн дурсгалуудын талаар хэд хэдэн сонирхолтой өгүүлэл нийтлүүлжээ.

Профессор Позднеевийн шавь А.Д.Руднев (1878-1958) 1903 онд монгол-манж хэлний чиглэлээр төгсөөд сургуульдаа багшаар үлджэ, “Монгол бичгийн хэл”, “Монгол ярианы хэл” зэрэг хичээл зааж байсны зэрэгцээ халимаг, буриад, халх болон өвөрлөгчдийн дунд судалгааны ажлаар олон удаа явж, баялаг материал цуглуулсныхаа үндсэн дээр “Дорнод Монголын аман аялгууны материал” гэсэн томоохон бүтээл туурвисан нь монгол хэл аялгууны судлалд үнэтэй хувь нэмэр болсон байна.

Петербургийн их сургуулийг А.Д.Рудневийн хамт төгссөн С.А.Козин монгол туургатны хэл, соёлын судалгааг олон жил хийж байгаад 1929 оноос Ленинградын их сургуулийн дорно дахины судлалын салбарт багшилж, хажуугаар нь алдарт “Гэсэр”, “Жангар”, “Монголын Нууц Товчоо” гурвыг орчуулан, тайлбар сэлтийн хамт нийтлүүлсэн нь туульсын зохиол судлалын эхлэл нь болсон байна.

XX зууны эхээр Петербургийн их сургуулийн монгол судлалын уламжлалт дэгийг Ленинградын дэг сургууль болгон хөгжүүлж, шинэ шатанд гаргаж, хөгжүүлсэн хүн бол Б.Я.Владимирцов юм. Тэрбээр Петербургийн их сургуульд хэлшинжлэлийн онолын талаар А.А.Шахматов, И.А.Бодуэн де Куртенэ, монгол хэл судлалын талаар профессор В.Котвич,

А.Д.Руднев, түрэг судлалын талаар В.В.Радлов, перс судлалын талаар В.В.Бартольд, буддын судлалын талаар Ф.И.Щербатской, С.Ф.Ольденбург зэрэг нэрт эрдэмтдийн хичээлд сууж, онолын өндөр мэдлэг эзэмшин төгсжээ. Их сургуулиа төгсөнгүүт багшаар үлдэж, "Монгол бичгийн хэл", "Монгол хэл аялгуу" зэрэг хичээлийг зааж эхэлжээ. Тэр бүр оюутан байхаасаа монгол нутгаар олон удаа аялж, ойрд, халх аялгуу болон аман зохиолын баялаг материал цуглуулж, улмаар түүнийгээ монгол бичгийн хэлтэй түүхэн үүднээс харьцуулан судалснаараа монгол хэлнүүдийн харьцуулсан судалгааг түүхэн харьцуулсан судалгааны түвшинд хүргэсэн байна. Түүнчлэн монголын нийгмийн байгуулал хийгээд монголын түүхэнд Чингис хааны гүйцэтгэсэн түүхэн үүргийг бодитойгоор үнэлсэн хэд хэдэн томоохон бүтээл туурвижээ.

Академич Б.Я.Владимирцовын үйл ажиллагааг залгамжлан Ленинградын монгол судлалын дэгийг үргэлжлүүлсэн дараа үеийнх нь шавь нар бол Н.Поппе (1897-1991), Г.Д.Санжеев (1902-1982) нар юм. Профессор Н.Поппе Ленинградын их сургуульд В.В.Бартольд, Ф.Щербатской, С.Ольденбург, Л.Щерба, В.Котвич, Б.Я.Владимирцов, С.Малов нарын зэрэг нэрт эрдэмтдийн хичээлд сууж, хэлшинжлэлийн онол, дорно дахины хэл, түүхийн өргөн мэдлэгтэй болжээ. Тэрбээр Их сургуулиа дүүргээд 1923 оноос 1943 он хүртэл 20 жил сургуульдаа багшилж, хажуугаар нь халимаг, буриад, монголд удаа дараалан очиж, тэдний хэл аялгууны талаар баялаг материал цуглуулан, хэд хэдэн томоохон бүтээл нийтлүүлжээ. Түүнчлэн монгол, дөрвөлжин, араб үсгийн монгол дурсгалуудын талаар гаргасан бүтээлүүдээрээ орос орны монгол судлалыг олон улсын тавцанд гаргаж чадсан байна.

Петербургийн их сургууль төгсөгчдийн дундаас монгол хэлний судлалд дорвитой хувь нэмэр оруулсан өөр нэгэн эрдэмтэн бол профессор Г.Д.Санжеев юм. Тэрбээр Ленинградын дорно дахины амьд хэлний дээд сургууль, дараа нь Б.Я.Владимирцовын удирдлагын дор аспирантурт суралцан төгсөөд, 1931 оноос Москвагийн дорно дахины судлалын хүрээлэнд ажиллах болжээ.

Петербург хот дахь Эзэн хааны Шинжлэх ухааны Академиас эрхлэн "Bulletin de l'Académie des Sciences de St.-Petersbourg", "Bulletin de la classe historico-philologique de l'Académie des sciences" зэрэг сэтгүүл гаргаж байсан бол Археологийн нийгэмлэгээс "Записки восточного отделения Императорского Русского Археологического общества" сэтгүүлийг тус тус гаргаж байжээ. Хожим XX зууны эхээр Зөвлөлт засаг байгуулагдсаны дараа ШУА-аас эрхлэн "Bibliotheca Buddhica" (1917-1936), "Известия Российской Академии наук" (1918-1919), "Записки Коллегии востоковедов" (1925-1930), "Доклады Академии Наук СССР" (1925-1930), "Записки Института Востоковедения Академии наук СССР" (1932-1939), "Труды Института востоковедения Академии наук СССР" (1932-1947), зэрэг сэтгүүлүүд гарч байжээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараагаас "Ученые записки Института востоковедения" (1950-1958), "Краткие сообщения Института востоковедения" (1951-1958), "Советское востоковедение" (1955-1958) зэрэг сэтгүүл гарч байсан бөгөөд дээрх хэвлэлүүдэд монголын түүх, соёлын тухай олон сонирхолтой өгүүллүүд нийтлэгдэж байжээ.

Гурав. Москва хотын Улсын Их Сургуулийн Ази-Африкийн орнууд судлалын хүрээлэн

М.В.Ломоносовын нэрэмжит Москва хотын Улсын Их Сургуулийн Ази-Африк орнуудын судлалын хүрээлэн 1956 оны 04 сарын 24 өдөр Дорно Дахины хэлний судлалын Хүрээлэн нэртэй байгуулагджээ. Анхны захирлаар түүхийн ухааны доктор профессор Н.А.Смирнов, 1958 оноос профессор А.А.Ковалев, 1975 оноос профессор Р.Т.Ахрамович, 2012 оноос И.И.Абылгазиев ажиллаж байна.

Тус хүрээлэнд монгол, араб, турк, пушту, солонгос, япон, хятад, вьетнам, тай, бирман, филиппин, перс, иврит, хинди, урду, дари, кхмер, малайз зэрэг дорно дахины хэлнээс гадна суахили, хауса, амхар, африкаан, фула гэх мэт африк хэл заадаг хийгээд элсэн сурагчид

хэлбичгийн ухаан, түүхч, улс төр судлаач, эдийн засагч гэсэн чиглэлийн аль нэгээр дагнан Дорно Дахин-Африк судлаач мэргэжил эзэмшиж төгсдөг.

Дөрөв. Алс Дорнодын Холбооны Их Сургууль

Алс Дорнодын Холбооны Их Сургууль (ОХУ-ын ерөнхийлөгчийн 2008 оны 5 сарын 7 өдрийн зарлигаар ийн нэрлэх болсон) анх Владивосток хотноо 1899 оны 10 сарын 21 өдөр Дорно Дахины Хүрээлэн нэртэй байгуулагджээ. Гэвч тухайн цаг үед мэргэжлийн боловсон хүчин хүрэлцэхгүй байсан учир Санкт-Петербургийн Их Сургуулийн төгсөгчдийг тус сургуулийн багшаар ажиллуулж байв. Анхны захирлаар А.М.Позднеев томилогдон 1903 он хүртэл ажиллаж байсан бөгөөд А.М.Позднеев ардыг гэгээрүүлэх яаманд шинэ албан тушаалд шилжсэнтэй холбоотой 1903 оны 11 сарын 30 өдрөөс Дорно Дахины Хүрээлэнгийн захирлаар А.В.Подставиныг томилжээ.

Орос Улсын дорнод нутгийн засаг захиргаа, худалдаа үйлдвэр эрхэлдэг байгууллагын боловсон хүчнийг бэлдэж гаргах явдал Дорно Дахины Хүрээлэнгийн зорилго байсан учир хятад-монгол, хятад-солонгос, хятад-манж, хятад-япон хэл гэсэн үндсэн дөрвөн салбараар сургаж байв. Түүнчлэн хөрш зэргэлдээ улс орнуудын хэл бичгийг судлах сонирхолтой хүмүүст зориулж оройгоор суралцах хэлний дамжаа нээжээ.

А.М.Позднеев өөрийн шавь болох А.В.Рудаков (солонгос судлаач), Е.Г.Спальвин (япон судлаач) нарыг багшаар авч ажиллуулсан бөгөөд 1898 онд Е.Г.Спальвиныг Япон, 1896 онд П.П.Шмидт, А.В.Рудаков нарыг гурван жилийн хугацаатай Бээжин рүү тус тус томилон сургасан байна. П.П.Шмидт, А.В.Рудаков нар 1899 онд буцаж ирээд хятад, манж хэл, Г.В.Подставин солонгос хэл, Г.Ц.Цыбиков монгол, төвөд хэл зааж байв.

Орос-Японы дайны үед Дорно Дахины Хүрээлэнг Дээд-Үд буюу одоогийн ОХУ-ын Улаан-Үд хот руу шилжүүлж, 1905 оны 02 сарын 04 өдрөөс хичээллэж эхэлсэн аж.

Маш богино хугацаанд Дорно Дахины Хүрээлэнгээс К.А.Харнский, Б.К.Пашков, А.В.Гребеншиков, Б.И.Панкратов, И.Г.Баранов, А.П.Хионин, А.Спицын, Н.К.Новиков зэрэг алдартай эрдэмтэд төрөн гарчээ.

ОХУ-ын ерөнхийлөгчийн 2008 оны 05 сарын 07 өдрийн зарлигаар Алс Дорнодын Холбооны Их Сургууль гэж нэрлэгдэх болсон.

Тав. Буриад Улсын Улаан-Үд хот дахь Монгол судлал, Оросын ШУА-ийн харьяа Монгол судлал, буддын судлал, төвд судлалын хүрээлэн

Улаан-Үд дэх монгол судлалын хамгийн томоохон төв нь Оросын ШУА-ийн харьяа Монгол судлал, буддын судлал, төвөд судлалын хүрээлэн юм. Тус хүрээлэн нь анх 1922 онд “Буриад-Монголын эрдмийн хороо” нэртэй байгуулагдаж, монгол аман зохиолын материал цуглуулах, сурах бичиг зохиох, нэр томьёо боловсруулах чиглэлээр ажиллаж байжээ. Тус хүрээлэн нь хожим “Буриад-Монгол Улсын Соёлын Хүрээлэн” (1929), “Улсын түүх, хэл утга зохиолын хүрээлэн” (1936), “Буриад-Монгол улсын эдийн засаг, соёл судлалын хүрээлэн” (1944), “ШУА-ийн Буриадын салбар” (1966) гэх мэтээр нэрлэгдэж байгаад 1997 оноос “Монгол судлал, буддын судлал, төвөд судлалын хүрээлэн” болжээ. Хэдийгээр тус хүрээлэн нь бүтэц бүрэлдэхүүнийхээ хувьд олон удаа өөрчлөгдсөн боловч монгол туургатны хэл, түүх, соёлыг судлах үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлсээр иржээ. Тус хүрээлэн байгуулагдсанаасаа хойш буриадын түүх, хэл соёл, аман зохиолтой холбогдол бүхий материал цуглуулах, хэвлэхээс гадна 1944 оноос мэргэшсэн боловсон хүчин бэлтгэгдэн гарсантай холбоотой үйл ажиллагааных нь хүрээ чиглэл өргөжсөн аж. Тухайлбал, Ф.А.Кудрянцев (буриад-монголын түүхээр судалгаа хийдэг байсан), Ц.Б.Цыдендамбаев (буриад хэл болон аялгуу судлал, буриад хэлний толь бичиг, буриадуудын түүх, аман зохиол судлал, угсаатны зүйн судлалаар олон

бүтээл туурвисан), Б.Д.Дандарон (15 мянган үгтэй төвөд-орос толь зохиосон. Мөн төвөд-орос гүн ухааны нэр томъёоны толийн зохиогч), Р.Е.Пубаев (төвд судлаач, Мэргэд гарахын орон нэрт толь бичгийн тэргүүн ботийг орчуулж хэвлүүлсэн), П.Б.Балданжапов (Цагаан түүх, Алтан товч, Зүрхэн толт зэрэг сурвалж бичгүүдийг судалсан), И.Д.Бураев (монгол, буриад хэлний авиазүй, аялгуу судлал), В.И.Рассадин (монгол-түрэг хэлний харьцуулсан судалгаа, харьцуулсан түүхэн хэлзүй, тофа хийгээд соёт хэлний цагаан толгойг зохиосон), Л.Д.Шагдаров (найруулга зүй, үгийн сан судлал, буриад хэлний зөв бичих зүй, монгол бичгээр уламжилж ирсэн бичиг үсгийн дурсгал судлал), У-Ж.Ш.Дондуков (буриад хэлний үгийн сан судлал, монгол хэлний үг бүтэх ёс), Ц.Б.Будаев (монгол, буриад хэлний авиазүй, аялгуу судлал), Н.Б.Дугаров (буриад хэлний үгийн сан судлал), зэрэг олон нэрт эрдэмтдийн өдий төдий бүтээлүүд гарсан байна.

Тус хүрээлэнгийн бүтэц дэх түүх, угсаатан судлал, барламал болон гар бичмэлийн судлал, хэл шинжлэл, утга зохиол, аман зохиол судлал, шашин, соёл судлал зэрэг салбаруудад монголчуудын хэл, түүх, соёлын холбогдолтой судалгааны олон ажил хийж байна.

2011 оноос “Оросын ШУА-ийн харьяа Монгол судлал, буддын судлал, төвөд судлалын хүрээлэнгийн мэдээ” эрдэм шинжилгээний бичигт түүх, археологи, угсаатны судлал, төвөд судлал, гүн ухаан, хэл бичиг зэрэг чиглэлээр туурвисан эрдэмтдийн бүтээлийг хэвлэх болжээ.

Монгол, буддын болон төвд судлалын хүрээлэн нь судалгааныхаа чиглэлээр Монгол, Хятад, Энэтхэг, Япон, Тайван, Өмнөд Солонгос, Герман, Франц, Англи зэрэг гадаад орнуудын дорно дахины судлалын төвүүдтэй нягт хамтран ажиллаж байна.

Зургаа. Буриад Улсын Улаан-Үд хот дахь Монгол судлал. Буриадын Улсын Их Сургуулийн Дорно Дахины Хүрээлэн Төв Азийн хэл бичгийн тэнхим

ОХУ-ын ерөнхийлөгчийн зарлиг болон Засгийн газрын тогтоолыг үндэслэн 1995 онд Дорж Банзаровын нэрэмжит Буриад Улсын Багшийн их сургууль, Новосибирск хотын Багшийн Их Сургуулийг нэгтгэн Буриад Улсын их сургуулийг байгуулжээ. Тус их сургуулийн Дорно дахины дээд сургуулийн бүрэлдэхүүнд багтдаг Төв Азийн хэл бичгийн тэнхим нь монгол судлалын гол төв юм.

Буриад Улсын Их Сургуулийн Дорно Дахины Дээд Сургуулийн Төв Азийн хэл бичгийн тэнхимийн түүх 1992 оноос эхлэлтэй бөгөөд Төв Азийн хэлбичгийн тэнхимийг нэрт монгол-түрэг судлаач профессор В.И.Рассадин (монгол-түрэг хэлний харьцуулсан судалгаа, харьцуулсан түүхэн хэлзүй, тофа хийгээд соёт хэлний цагаан толгойг зохиосон) 2005 он хүртэл толгойлж байсан.

Буриад Улсын Их Сургууль нийт 12 факультет, 3 хүрээлэн, 2 салбар сургуулийг багтаасан ОХУ-ын томоохон их сургуулийн нэг юм.

Буриад Улсын Их Сургуулийн Дорно Дахины Дээд Сургуулийг 1992-2001 онд доктор, профессор Янгутов Леонид Евграфович, 2001-2005 онд доктор, профессор Бураев Дмитрий Игнатьевич, 2005-2011 онд доц. Шохоев Эдуард Климентьевич, 2011 оноос док. Дашинимаева Полина Пурбуевна удирдаж байна. Дорно Дахины Дээд Сургууль нь 1. Алс Дорнодын хэл бичгийн тэнхим (тэнхимийн эрхлэгч: доктор Тугулова Ольга Доржиевна), 2. Төв Азийн хэл бичгийн тэнхим (тэнхимийн эрхлэгч: доктор Бадагаров Жаргал Баяндалаевич), 3. Угсаатны зүй-түүх археологийн тэнхим (тэнхимийн эрхлэгч: доктор Бураев Дмитрий Игнатьевич), 4. Бүс нутаг судлалын тэнхим (тэнхимийн эрхлэгч: доктор Аюшиева Ирина Гармаевна) гэсэн үндсэн дөрвөн тэнхимтэй.

Өнөөдрийн байдлаар тус сургуульд элсэгчид монгол, турк, солонгос, япон, төвд, хятад хэлний аль нэгийг сонгож дорно дахины судлал ба африк судлал гэсэн үндсэн хоёр чиглэлээр мэргэшин төгсдөг.

Буриадын Их Сургуулийн “Буриад Улсын Их Сургуулийн мэдээ. Дорно дахины судлал” эрдэм шинжилгээний бичигт монгол, япон, хятад, солонгос ард түмний хэл, соёл, түүх, шашны талаар бичсэн эрдэмтдийн судалгааны бүтээл хэвлэгддэг.